



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат
Утас: 7037-3089
Цахим хаяг:
Chultembat.ch100@yahoo.com

Аудитын менежер: Ш.Мөнхбаяр
Утас: 7037-8845
Цахим хаяг:
muugii.sharav@yahoo.com

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 7037-4605
Цахим хаяг: bagii0526@yahoo.com

ТАБ-ын хаяг: Дархан-Уул аймаг
дахь Төрийн Аудитын газар
Байршил: Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 4 дүгээр сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 5: Судалгаа

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
4. Дотоод хяналт
5. Санхүүгийн тайлангийн дансдын талаар
6. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
7. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
8. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
9. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
10. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
11. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
13. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Дархан-Уул аймаг дахь Төрийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд /ДАУ-2018/1/СТА-ТЭЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв. ТЭЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

ТЭЗ санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн нэгтгэсэн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Дархан-Уул аймгийн орон нутгийн төсвийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг 2018 оны 04 дүгээр сарын 02-нд Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 01-нээс 2018 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Дархан-Уул аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “*Аймаг, нийслэл, сум, дүүрэг төсөвтэй байна*”, 6.2-т “*Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна*” гэж заасан.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “*төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ*” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Засаг дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна”, 54.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” гэж заасны дагуу аймгийн орон нутгийн төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гарган ирүүлсэн байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар баталсан журам, заавруудыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар тус аймгийн орон нутгийн төсвийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын эрсдэлийг тогтоон удирдлагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Аймгийн орон нутгийн төсвийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн байдлын тайлан дахь нийт хөрөнгийн 2 хувь буюу 2,757.3 сая төгрөгөөр тогтоов.

ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад орон нутгийн төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайланг нэгтгэх үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна. Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Аймгийн орон нутгийн төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайланд төсвийн шууд захирагчийн 91, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 15 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд 106 байгууллага аудит хийлгэн, дүгнэлт гаргуулжээ. Хувийн 9 сургууль, 21 цэцэрлэгийн орон нутгийн төсвөөс авсан татаас, санхүүжилтийг тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн санхүүгийн аудитаар тулган баталгаажуулсан. Аудитад хамрагдсан байгууллагуудын 29.2 хувьд Төрийн аудитын газар, 70.8 хувьд хараат бус аудитын компани санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг хийв. Аудитаар Энэрэл цогцолбор болон 1 дүгээр сургуулиуд хязгаарлалттай санал дүгнэлт авч, бусад байгууллагууд “зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын алба 47 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийжээ.

Шалгалтаар нийт 261 заалт бүхий 124 акт тогтоосноос 95 актыг биелүүлж, 29 актын хугацаа болоогүй, актын биелэлт 77.0 хувьтай байна.

2017 онд нийт 315.7 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн бөгөөд нийт зөрчлийн 16.2 хувь нь үндсэн баримтгүй зарцуулсан буюу данс бүртгэлд тусгаагүй, 0.2 хувь нь албан татвар, төлбөр хураамжийн, 19.5 хувь нь цалин хөлстэй холбоотой, 1.7 хувь нь төсвийн хөрөнгийг ашиглаж, дутагдуулсан, 38.5 хувь нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, 1.2 хувь нь өр авлага үндэслэлгүй хаасан, 1.7 хувь нь түрээсийн төлбөрийн, 1.0 хувь нь шийдвэргүйгээр ойн баяр тэмдэглэх, хандив бэлэг шагнал олгосон, 12.5 хувь нь төсвийн мөнгийг бусдад зээлдүүлж түр ашиглуулсан, 7.5 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй, өндөр үнээр худалдан авах буюу хямд үнээр худалдсан зэрэг бусад зөрчлүүд илэрсэнд арга зүйн заавар зөвлөмж өгч ажилласан байна.

Хяналт шалгалтаар илэрч буй зөрчлүүд нь ажилдаа хайнга хандсанаас, санхүүгийн сахилга бат сул байгаагаас, тухайн албан тушаалтныг томилох чөлөөлөх эрх бүхий хуулийн этгээдээс тавих хяналт муугаас, хариуцлага тооцдоггүй, ажил дүгнэх үйл явц ёс төдий цаас бүрдүүлэх маягаар ажил үүргээ гүйцэтгэж байгаа зэргээс шалтгаалан гарчээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан эрх бүхий байгууллагын заавар, журмыг хэрэгжүүлж, бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн нэгтгэлийн програмаар боловсруулжээ.

Санхүүгийн тайлангийн дансдын талаар:

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд мөнгөн хөрөнгийг дараах байдлаар бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

/сая.төг-өөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Касст байгаа бэлэн мөнгө	17.7	15.6
Банкинд байгаа мөнгө	4,205.2	4,364.7
Төрийн сангийн харилцах	3,704.4	2,884.2
Арилжааны банк	55.5	67.1
Гадаад валют	445.3	1,413.4
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	4,222.9	4,380.3

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд Дархан бохир усны менежментийг сайжруулах МОН3244/3245 төслийн гадаад валютын 1,413.4 сая төгрөг нөлөөлсөн

байна. Дээрх МОН/3245 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хугацаа хойшилж, ажлын гүйцэтгэл гараагүйгээс гадаад валютаарх үлдэгдэл их хэмжээтэй тайлагнагджээ.

Касст байгаа 15.6 сая төгрөг нь Дархан Ус суваг ОНӨХК-ийн 14.9 сая, Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ-ын 0.7 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 4,364.7 сая төгрөгийн 66.1 хувь буюу 2,884.2 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансанд, 33.9 хувь буюу 1,480.5 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж байна.

Харилцах дансны үлдэгдлийн 99.61 хувь буюу 4,363.4 сая төгрөг нь доорх байгууллагуудын дансанд байна. /сая төгрөгөөс дээш үлдэгдэлтэйг хамруулав/

- Госхот ӨЭМТ 3.6 сая,
- Гэрэлтэй ӨЭМТ 3.5 сая,
- Түвшин холбоо ӨЭМТ 5.1 сая,
- Дархан Ус суваг ОНӨХК 28.4 сая,
- Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ 10.7 сая,
- Эмт наран ОНӨААТҮГ 12.2 сая,
- Аймгийн Төрийн сан 1,888.7 сая,
- Орон нутгийн хөгжлийн сан 466.2 сая,
- Дархан бохир усны менежмент төсөл 1,458.0 сая,
- Дархан сумын Төрийн сан 280.7 сая,
- Хонгор сумын Төрийн сан 70.9 сая,
- Орхон сумын Төрийн сан 48.6 сая,
- Шарын гол сумын Төрийн сан 59.6 сая,
- Хонгор сумын Нөхөн сэргээлт барьцаа хөрөнгө 22.8 сая,
- Шарын гол сумын Нөхөн сэргээлт барьцаа хөрөнгө 4.4 сая.

2. Авлагын бүртгэл, тайлагнал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд авлагын эхний үлдэгдэл 3,625.8 сая төгрөг байснаас тайлант онд 365.4 сая төгрөгөөр буурч, оны эцэст 3,260.4 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

Авлагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Ажиллагчидтай холбогдсон авлага	4.8	2.8	(2.0)
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,346.1	1,236.8	(109.3)
Татаас, санхүүжилтийн авлага	284.7	385.5	100.8
Дансны авлага /ТӨҮГ/	0.4	18.4	18.0
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	1.4	2.9	1.5
Байгууллагаас авах авлага	241.1	170.2	(70.9)
Хувь хүмүүсээс авах авлага	1,747.3	1,443.8	(303.5)
Дүн	3,625.8	3,260.4	(365.4)
Байгууллагын төрлөөр			
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	1,389.1	1,289.4	(99.7)
Төрийн сан	33.6	111.4	77.8
Төсөвт байгууллага	2,203.1	1,859.6	(343.5)
Дүн	3,625.8	3,260.4	(365.4)

Хүснэгтээс үзэхэд ажиллагчидтай холбоотой болон төлбөртэй үйлчилгээний авлага, байгууллагаас болон хувь хүмүүсээс авах авлага 2.0-303.5 сая төгрөгөөр буурсан байхад татаас, санхүүжилтийн, татвар, НДШ-ийн, дансны авлага 1.5-100.8 сая төгрөгөөр өсчээ.

Авлагыг төрлөөр нь авч үзвэл хүмүүстэй холбогдсон авлага 1,443.8 сая төгрөг буюу 44.3 хувь, төлбөртэй үйлчилгээний авлага 1,236.8 сая төгрөг буюу 37.9 хувь, татаас, санхүүжилтийн авлага 385.5 сая төгрөг буюу 11.8 хувь, дансны авлага 18.4 сая төгрөг буюу 0.6 хувь, татвар, НДШ-ийн авлага 2.9 сая төгрөг буюу 0.1 хувь, ажиллагчидтай холбогдсон авлага 2.8 сая төгрөг буюу 0.1 хувь, байгууллагаас авах авлага 170.2 сая төгрөг буюу 5.2 хувийг эзэлж байна.

Нийт авлагын 39.6 хувь буюу 1,289.4 сая төгрөг нь төрийн өмчит үйлдвэрийн газарт, 3.4 хувь буюу 111.4 сая төгрөг нь төрийн санд, 57.0 хувь буюу 1,859.6 сая төгрөг нь төсөвт байгууллагад байна.

Төрийн сангийн авлагын 77.8 сая төгрөгийн өсөлт нь Дархан сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд дахь нийт авлагын 95.58 хувийг Дархан Ус суваг ОНӨХК-ний авлага, харин төсөвт байгууллагуудын авлагын 93.8 хувийг сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага эзэлж байна.

3. Бараа материалын бүртгэл, тайлагнал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 3,836.8 сая төгрөг байснаас оны эцэст 3,994.9 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан дүнгээр авч үзвэл :

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Түүхий эд материал	493.4	553.9	60.5
Бэлэн бүтээгдэхүүн	14.1	0.0	(14.1)
Хангамжийн материал	3,299.6	3,415.4	115.8
Мал амьтад	29.7	25.6	(4.1)
Дүн	3,836.8	3,994.9	158.1

Нийт өсөлтийн 73.2 хувийг хангамжийн материал эзэлж байна.

Хангамжийн материалыг төрлөөр авч үзвэл:

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Бичиг хэргийн материал	135.6	138.0	2.4
Аж ахуйн материал	1,360.9	1,449.5	88.6
Сэлбэг хэрэгсэл	36.5	57.4	20.9
Түлш, шатах тослох материал	23.7	20.4	(3.3)
Барилгын засварын материал	51.3	56.2	4.9
Хүнсний материал	210.9	109.1	(101.8)
Бусад хангамжийн материал	1,480.7	1,584.8	104.1
Дүн	3,299.6	3,415.4	115.8

Бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, барилгын засварын материал, бусад хангамж, аж ахуйн материал 2.4-104.1 сая төгрөгөөр өссөнөөс харахад бараа материалыг шаардлагатай хэмжээнээс илүүгээр бэлтгэж нөөцөлсөн байдал ажиглагдлаа. Тухайлбал төсөвт байгууллагуудаас Байгаль орчин аялал жуулчлалын газар 10.6 сая, НААҮГ 24.2 сая, Дархан сумын ЗДТГ 7.4 сая, Орхон сумын ЗДТГ 11.3 сая, Хонгор сумын ЗДТГ 16.1 сая төгрөгөөр тус тус бараа материал нэмэгдсэн байна.

Өмнөх оны аудитаар бараа материал нөөцөлсөн тухай дурьдаж байсан ч энэ удаа дахин давтагдан гарч байгаад анхаарах шаардлагатай.

4. Урьдчилж төлсөн зардлын бүртгэл, тайлагнал

Урьдчилж төлсөн зардал тайлант оны эхэнд 91.3 сая төгрөг байснаас 39.6 сая төгрөгөөр буурч, оны эцэст 51.7 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Байгууллагаар нь авч үзвэл:

- Дархан Ус суваг ХК 19.2 сая,
- Аймгийн ИТХ 8.0 сая,
- Орхон сумын ЗДТГ 24.5 сая

Урьдчилж гарсан зардлын 37.1 хувь буюу 58.7 сая төгрөг ОНӨХК-д, 62.9 хувь буюу 32.5 сая төгрөг төсөвт байгууллагад ногдож байна.

5. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 114,933.0 сая төгрөг байснаас тайлант онд 11,215.4 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 126,148.4 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт үндсэн хөрөнгийн 67.9 хувь нь төсөвт байгууллагуудад, 32.1 хувь нь ОНӨҮГ-т бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь ангилбал дараах байдалтай байна:

Үндсэн хөрөнгийн нэр төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Барилга байгууламж, орон сууц	53,999.2	54,537.8	538.6
Автотээврийн хэрэгсэл	1,233.1	1,193.6	(39.5)
Машин тоног төхөөрөмж	2,998.2	2,901.8	(96.4)
Тавилга эд хогшил	1,615.2	1,606.8	(8.4)
Зам гүүрийн байгууламж	15,054.2	19,461.4	4,407.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	553.3	562.8	9.5
Бусад үндсэн хөрөнгө	29,133.0	29,762.7	629.7
Дуусаагүй барилга байгууламж	9,356.1	14,951.9	5,595.8
Номын фонд	725.0	748.8	23.8
Програм хангамж	84.6	84.2	(0.4)
Бусад биет бус хөрөнгө	181.1	336.6	155.5
Дүн	114,933.0	126,148.4	11,215.4

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 99.7 хувийг биет хөрөнгө, 0.3 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 33,364.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс 415.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 4,736.0 сая

төгрөгийн хөрөнгийг хандиваар, 22,202.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн, 6,009.6 сая төгрөгийн хөрөнгийг бусад эх үүсвэрээр авсан байна.

2017 онд 17,939.5 сая төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсанаас эрх бүхий байгууллагын шийдвэрээр 382.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 87.9 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр, 17,442.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн, 26.7 сая төгрөгийн хөрөнгө бусад шалтгаанаар хасагджээ.

6. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 2,548.5 сая төгрөг байснаас тайлант онд 7,957.6 сая төгрөгөөр өсч, оны эцэст 10,506.0 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Төрийн сан	145.5	8,290.7	8145.2
ОН-ийн байгууллага	522.8	410.7	(112.1)
ОНӨҮГ	1,880.1	1,804.6	(75.5)
Дүн	2,548.4	10,506.0	7,957.6

/сая.төгрөгөөр/

Тайлант онд өр төлбөр 7,875.9 сая төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр санхүүжиж байгаа төслийн нэгж буюу Дархан бохир усны менежментийг сайжруулах МОН3244/3245 төслийн гадаад валютаарх зээлтэй холбоотой байна.

Нийт өр төлбөрийн 78.9 хувийг Төрийн сан дахь өр төлбөр, 17.2 хувийг ОНӨҮГ-ын өр, 3.9 хувийг төсвийн байгууллагуудын өр төлбөр эзэлж байна.

Төрийн сан дахь үлдэгдэл нь Дархан бохир усны менежментийг сайжруулах МОН3244/3245 төслийн 7,884.8 сая төгрөгийн зээлээс гадна төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн болон Хонгор, Орхон, Шарын гол сумдын сум хөгжүүлэх сангийн оны эцсийн харилцах дансны үлдэгдлийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэнтэй холбоотойгоор үүссэн өр төлбөр байна.

ОНӨҮГ-ын өр төлбөрийн дийлэнх буюу 1,786.6 сая төгрөгийн өр төлбөр нь Дархан Ус суваг ОНӨХК-ийн өр төлбөр эзэлж байна.

7. Цэвэр хөрөнгө, өмчийн талаар

а. Засгийн газрын сан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Засгийн газрын сан дансны эхний үлдэгдэл 44,385.2 сая төгрөг байснаас тайлант онд 20,261.9 сая төгрөгөөр өсч, оны эцэст 64,647.1 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

/сая.төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ОН-ийн байгууллага	10,314.8	10,300.7	(14.1)
ТЗШ-ийн байгууллага	27,367.7	27,367.7	0.0
ОНӨҮГ	6,702.7	26,978.7	20,276.0
Дүн	44,385.2	64,647.1	20,261.9

Тайлант үеийн өсөлтийн шалтгаан нь аймгийн ИТХ-ын 2016 оны 94 дүгээр тогтоолоор Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ шинээр бий болсонтой холбоотой байна.

Засгийн газрын санг байгууллагын төрлөөр задалж харвал орон нутгийн байгууллагын үлдэгдэл 14.1 сая төгрөгөөр буурч, ОНӨҮГ-ын үлдэгдэл 20,276.0 сая төгрөгөөр өсч, ТЗШ-ийн байгууллагын үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсөвт байгууллагын Засгийн газрын сангийн бууралт нь Худалдан авах ажиллагааны алба татан буугдсантай холбоотой байна.

ОНӨҮГ-ын эздийн өмчийн өсөлтийн 54.4 сая төгрөг нь Хонгор сумын “Эмтнаран” ОНӨААТҮГ-т аймгийн болон сумын Засаг даргын нөөц сангаас хөрөнгө бэлтгэснээс нэмэгджээ. Харин 13.6 сая төгрөгийн өсөлт нь Дархан Ус суваг ОНӨХК-ийн 2016 оны тайланд гарсан алдааг залруулснаас үүссэн байна.

б. Хуримтлагдсан үр дүн

ТЕЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Хуримтлагдсан үр дүнгийн оны эхний үлдэгдэл 21,263.6 сая төгрөг байснаас тайлант онд 18,626.3 сая төгрөгөөр буурч, оны эцэст 2,637.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Тайлант үеийн 18.563,6 сая төгрөгийн алдагдал болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр 62.7 сая төгрөг хасагдсан нь бууралтад нөлөөлжээ.

в. Дахин үнэлгээний нөөц

Дахин үнэлгээний нөөц данс нь үндсэн хөрөнгө актлагдсантай уялдаж, 10.3 сая төгрөгөөр буурч, 2017 оны эцэст 44,157.4 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

8. Орлого, татаас санхүүжилтийн талаар

а. Орон нутгийн орлого

Дархан-Уул аймгийн орон нутгийн төсвийн нийт орлого 20,856.9 сая төгрөгөөр төлөвлөснийг 102.8 хувийн биелэлттэй буюу 587.8 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр харуулбал дараах байдалтай байна:

Орлогын нэр төрөл	/сая.төгрөгөөр/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	19,746.3	20,064.6	318.3	101.6
Хувь хүний орлогын албан татвар	16,940.5	17,076.1	135.6	100.8
Цалин хөлс түүнтэй адилтгах ОАТ	15,086.2	15,247.6	161.4	101.1
Үйл ажиллагааны орлого	261.6	233.5	(28.1)	89.2
Хөрөнгө борлуулсны ОАТ	518.5	449.4	(69.1)	86.7
Бусад орлого	1,074.2	1,145.6	71.4	106.6
ХХОАТ-ын буцаалт	(1,643.2)	(1,643.2)	0.0	100.0
Хөрөнгийн албан татвар	1,890.4	1,938.7	48.3	102.6
Үл хөдлөх хөрөнгийн татвар	1,300.0	1,335.1	35.1	102.7
Бууны албан татвар	30.4	18.7	(11.7)	61.5
Автотээвэр болон ӨЯХАТ	560.0	584.9	24.9	104.4
Бусад татвар	1,988.0	1,989.6	1.6	100.1
Улсын тэмдэгтийн хураамж	463.0	377.4	(85.6)	81.5

Газрын төлбөр	652.0	664.7	12.7	101.9
Газрын дуудлага худалдааны орлого	418.0	477.4	59.4	114.2
Түгээмэл тархацтай АМАТ	33.0	38.8	5.8	117.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	422.0	431.3	9.3	102.2
Байгалийн нөөц ашигласны төлбөр	570.6	703.4	132.8	123.3
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	541.9	670.5	128.6	123.7
Ойн нөөц ашигласны төлбөр	26.5	31.9	5.4	120.4
Байгалийн ургамал ашигласны төлбөр	2.2	1.0	(1.2)	45.4
Татварын бус орлого	1,110.6	1,380.1	269.5	124.3
Хүү, торгуулийн орлого	800.0	986.7	186.7	123.3
Төсөвт байгууллагын өөрийн орлого	168.6	190.5	21.9	113.0
Бусад орлого	142.0	202.9	60.9	142.9
Нийт орлого	20,856.9	21,444.7	587.8	102.8

Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн орлого 21,444.7 сая төгрөгт хүрч орлогын төлөвлөгөөг 587.8 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар давуулан биелснээс татварын орлого 318.3 сая төгрөгөөр, татварын бус орлого 269.5 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна. Татварын орлого нийт дүнгээр биелсэн боловч зарим орлогын биелэлт хангалтгүй байв. Тухайлбал: Байгалийн ургамал ашигласны төлбөр 54.6 хувиар, бууны албан татвар 38.5 хувиар, хөрөнгө борлуулсны болон үйл ажиллагааны орлого, улсын тэмдэгтийн хураамж 10.8-18.5 хувиар тус тус тасарсан байна. Хөрөнгө борлуулсны орлогын албан татварын хувьд ипотекийн зах зээлээс шалтгаалан үл хөдлөх хөрөнгө, түүний дотор орон сууцны борлуулалт буурснаас тасалдсан бол байгалийн баялаг ашиглахтай холбоотой төсөвт төвлөрөх орлогуудын хувьд үйлдвэрлэлийн салбарын өсөлт сайнгүй байгаа нь нөлөөлжээ.

Харин татварын бус орлогын хувьд төлөвлөгөөг 24.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

б. Татаас, санхүүжилтийн талаар

2017 онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 270.3 сая төгрөгийн төвлөрүүлэлтийг 100 хувь төвлөрүүлж, сумдад 1,057.4 сая төгрөг татаасаар олгосон ба Дархан сум аймгийн төсөвт төвлөрүүлэх 1,063.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 77.8 сая төгрөгийг дутуу төвлөрүүлжээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 1,773.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 33,967.9 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд санхүүжилтүүд төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрсөн байна.

9. Зарлагын талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны орон нутгийн төсвийн нийт зарлага 71,234.1 сая төгрөгөөр батлагдсанаас 64,403.3 сая төгрөг зарцуулж, төсвийг 6,830.8 сая төгрөгөөр хэмнэжээ.

Цалин хөлсний зардлаас 54.2 сая, ажил олгогчийн төлөх НДШ-ийн зардлаас 7.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 18.2 сая, хангамж, бараа материалын зардлаас 3.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнээс 4,523.4 сая, бараа үйлчилгээний бусад зардлаас 233.9 сая, хувийн хэвшилд олгох татаасаас 21.2 сая, урсгал шилжүүлгээс 522.2 сая, хөрөнгө оруулалтаас 1,055.4 сая, эргэж

төлөгдөх зээлээс 389.6 сая төгрөгийг тус тус хэмнэснээс харахад нийт хэмнэлтийн 66.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, 15.4 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын хэмнэлт нь Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төслийн хөрөнгөөр хийгдэх ажлын гүйцэтгэл төлөвлөснөөс дутуу хийгдсэнтэй холбоотой.

Хөрөнгө оруулалтын зардлын хэмнэлт нь хөрөнгө оруулалт болон ОНХС-аар хийгдсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, мөн дууссан ажлын гүйцэтгэлийн баталгаа болон он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалттай холбоотойгоор үүсчээ.

10.Хөрөнгө оруулалтын талаар

Дархан-Уул аймагт 2017 онд 3 салбарт нийт 4,313.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ажлыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжүүлснээс гүйцэтгэлээр 4,283.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 29.9 сая төгрөгөөр хэмнэжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын гүйцэтгэлийг төсөл арга хэмжээ бүрээр задалбал:

- "Дулаан Шарын гол" ТӨХК-ийн Дулааны станцаас дулаан хуваарьлах төв хүртэлх гадна дулааны 2.2 км төв шугамын өргөтгөл, шинэчлэлд 3,888.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 10.1 сая төгрөгөөр,
- "Од" цогцолбор сургуулийн барилгын дээврийн засварт 85.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 14.8 сая төгрөгөөр,
- Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлд 98.4 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1.6 сая төгрөгөөр,
- "Оюуны Ирээдүй" цогцолбор сургуулийн "А" байрны дээврийн засварт 69.9 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 0.1 сая төгрөгөөр,
- Нэгдсэн эмнэлгийн сэтгэц, наркологийн тасгийн барилгын дээврийн засварт 53.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 2.1 сая төгрөгөөр,
- 1 дүгээр сургуулийн гадна цэвэр усны шугам, спорт заалны засварт 49.5 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 0.5 сая төгрөгөөр,
- 18 дугаар сургуулийн дулааны узель, ялтсан дулаан солилцуурын засварт 39.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 0.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хувьд аймгийн Засаг дарга худалдан авах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулснаас гадна гүйцэтгэгч компанитай байгуулсан ажил гэрээт хугацаандаа бүрэн хийгдэж, үр дүнтэй хэрэгжсэн байна.

Орон нутгийн төсвөөс хийгдэх хөрөнгө оруулалтад 2017 онд 5,827.8 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 5,281.2 сая төгрөгийг зарцуулжээ. Нийт төсөл, арга хэмжээний 4.1 хувь нь барилга барихад, 95.9 хувь нь бусад хөрөнгөнд зарцуулагджээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 4 ажлаас бусад нь гэрээт хугацаандаа бүрэн хийгдсэн байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн аудитаар ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, төсвийг хохироосон зөрчлүүдийг арилгуулах 15.3 сая төгрөгийн 3, хөрөнгийг бүртгэлд тусгуулах 403.3 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хүргүүлжээ.

11. Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

Дархан-Уул аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хийж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/05 дугаар тогтоолоор тодотгон баталсан жагсаалтаар 116 төсөл, арга хэмжээг 1,595.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр баталжээ.

Тус сангийн дансанд 2017 оны эхэнд 798.0 сая төгрөгийн шилжих үлдэгдэлтэй, улсын төсвийн санхүүжилтээр 1,773.3 сая төгрөг, аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 296.6 сая, нийт 2,069.9 сая төгрөгийг бүрдүүлэн, хөрөнгө оруулалтад 1,126.4 сая, НААҮГ, Эмтнаран ОНӨААТҮГ-ын урсгал зардалд 1,275.3 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 466.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс Дархан-Уул аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 1,773.3 сая, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг 1,275.3 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 7 ажлаас бусад нь гэрээт хугацаандаа бүрэн хийгджээ.

12. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тайлант онд Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хяналт тавихад 18 байгууллага дээрх хуулийн 6 дугаар зүйлд заасан зарим мэдээллийг бүрэн байршуулаагүй байлаа. Үүнд:

- “Энэрэл” цогцолбор сургууль тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т заасан 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 30.5 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй,
- Орон нутгийн 5 байгууллага, тусгай зориулалтын шилжүүгийн 6 байгууллага уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 823.8 сая төгрөгийн орлогын 32, 563.0 сая төгрөгийн зарлагын 32 гүйлгээг тус тус байршуулаагүй,
- Байгаль орчин аялал, жуулчлалын газар болон тусгай зориулалтын шилжүүгийн 6 байгууллага хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 404.5 сая төгрөгийн 43 шийдвэрийг мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Дээрх зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага өгч, биелэлтийг бүрэн хангуулсан бөгөөд дээрх байгууллагын нягтлан бодогч нарт хуулийн дагуу сахилгын хариуцлага тооцуулсан.

Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба дээрх хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байлаа.

Тус албанаас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2017 оны 1, 2 дугаар улирлыг хамруулан шалгаж, хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг байршуулахдаа хугацаа хоцроосон, 2 дугаар улирлын тайланг илгээгээгүй байгууллагын төсвийн шууд захирагч нарт аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/419 дугаар захирамжаар сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Үр дагаврыг тодорхойлбол: Төсвийн зарим шууд захирагч нар орлого, зардлыг ангилал зөрүүлэх, элэгдлийн зардлыг буруу тооцоолох, дээд шатны тушаал шийдвэргүйгээр цалингийн нэмэгдэл авах, бараа материалыг төлбөр тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэх, хөрөнгийг зардлаар бүртгэх, тооллогын дүн санхүүгийн тайлангаас зөрөх, УИХ-ын тогтоол болон Сангийн сайдын тушаалыг зөрчих, цалин давхардуулан олгох, өр авлага үүсгэх, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байх, батлагдаагүй орон тоонд хавсран ажилласны нэмэгдэл олгох, татвар болон НДШ-ийн тайлан санхүүгийн тайлангаас зөрөх зэрэг зөрчлүүд илэрсэн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитаар санхүүгийн тайлангийн дансдын үлдэгдлүүдийг тулган шалгалаа.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн төсвийн багцын байгууллагуудаас ОНӨҮГ-ын 3, төсвийн 3 байгууллага “Төсөвт байгууллагын Е тайлан” системд санхүүгийн тайлангаа шивэхдээ зарлагын ангиллыг зөрүүлэх, зардлуудыг “бараа үйлчилгээний бусад зардал”-д бөөн дүнгээр оруулах, улмаар ТЕЗ-ийн санхүүгийн тайланг нэгтгэж буй ажилтнууд аудит хийгдсэн санхүүгийн тайлантай нэг бүрчлэн тулгаж авахгүй

байгаа зэргээс 53.0 сая төгрөгийн зардал ангилал зөрсөн, 103.2 сая төгрөгийн зардал хоорондоо гүйсэн байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг мөрдөж, төсвийн шууд захирагч нарын тайланг нэгтгэхдээ хяналтыг сайжруулж, байгууллага бүрийн тайланг аудит хийгдсэн дүнтэй тулган авч байх зөвлөмж өгснийг хүлээн авсан.

2. 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн тодотголоор халамжийн сангийн зардлыг 463.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд гүйцэтгэлээр уг зардал 489.6 сая төгрөгөөр хэмнэгджээ. Халамжийн сангийн 2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах явцад тодруулахад ХХҮГ нь зардал нэмэгдүүлэх санал, тооцооллыг өгөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 31 дүгээр зүйлийн 31.4.5 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийг төлөвлөх болон тодотгохдоо Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг баримталж, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэж байх зөвлөмж өгснийг хүлээн авсан.

3. Дархан Ус суваг ОНӨХК-д орон нутгийн төсвөөс олгож буй 108.1 сая төгрөгийн усны үнийн зөрүүг “хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас” зардлын ангилалд оруулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Мөн Ахмадын хорооны ажиллагсдын 5.1 сая төгрөгийн урамшууллыг уг байгууллагын санхүүжилтээс тусад нь “нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал” зардлаар төлөвлөжээ.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлын хариуд төсвийн захирагч уг асуудлыг хасуулах санал өгсөн. Сангийн сайдын дээрх тушаалын 6 дугаар хавсралтад:

- “Төрийн өмчит байгууллагад олгох татаас” ангилалд Төрийн өмчит байгууллагад олгож байгаа татаасыг энэ ангилалд бүртгэхээр,
- “Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас” ангилалд хувийн хэвшлийн байгууллагад олгож байгаа татаасыг бүртгэхээр заасан байх тул хэвээр үлдээлээ.

Төсвийг төлөвлөхдөө Сангийн сайдын баталсан “эдийн засгийн ангилал”-ыг баримтлах, ахмадын хорооны ажиллагсдын урамшууллыг тухайн байгууллагад олгож буй санхүүжилтийн дүнд оруулж төлөвлөж байх зөвлөмж өгсөн болно.

4. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын удирдах ажилтнуудын 2017 оны эхний хагас жилийн ажлыг дүгнэсэн боловч сүүлийн хагас жилд ур чадварын нэмэгдлийг олгох шийдвэр гараагүй байна. Гэвч 1, 6, 7, 9, 11, 13, 14, 15, 16, 17, 21, 22 дугаар цэцэрлэгүүд, Жигүүр цогцолбор, 30 дугаар сургууль, Музей, Номын сан зэрэг 16 байгууллага 10.9 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр олгожээ. Энэ нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4

дүгээр хавсралтын 4 дэх “Ур чадварын нэмэгдлийг олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг энэ журмын 2, 8-д заасан шалгуурыг үндэслэн тухайн байгууллагын эрх баригчийн тушаалаар шийдвэрлэнэ” гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Дотоод хяналтыг сайжруулж, дээрх алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг хүлээн авсан.

5. Музейн захирал хүчингүй болсон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг үндэслэл болгон, хоёр тушаал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн шууд захирагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, чадавхижуулахад анхаарч, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгснийг хүлээн авсан.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 4,695.9 сая төгрөгийн алдааг залруулж, хууль, журам, заавар мөрдөөгүтэй холбогдон гарсан 2,035.9 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 7,756.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,695.9 сая төгрөгийн алдааг залруулж, 2,499.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 18.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 541.6 сая төгрөгийн албан шаардлага өгсөн байна.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн нь тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтрээгүй болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хянаж, үнэлэхэд 50 хувийн биелэлттэй буюу төсвийн төслийг хянахдаа бараа материалын нөөцийг харгалзан үзэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлангийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 9 хуудас, хавсралт 8 хуудсыг хавсаргав.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018.04.20.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь *Дархан-Уул аймгийн Засаг дарга буюу ТЕЗ-ийн* нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Илрүүлэлт

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн төсвийн багцын байгууллагуудаас ОНӨҮГ-ын 3, төсвийн 3 байгууллага нь “Төсөвт байгууллагын Е тайлан” системд санхүүгийн тайлангаа шивэхдээ зарлагын ангиллыг зөрүүлэх, зардлуудыг “бараа үйлчилгээний бусад зардал”-д бөөн дүнгээр оруулах, улмаар ТЕЗ-ийн санхүүгийн тайланг нэгтгэж буй ажилтнууд аудит хийгдсэн санхүүгийн тайлантай нэг бүрчлэн тулгаж авахгүй байгаа зэргээс 53.0 сая төгрөгийн зардал ангилал зөрсөн, 103.2 сая төгрөгийн зардал хоорондоо гүйсэн байна.

Хариуцах ажилтан

Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий нягтлан бодогч

Эрсдэлүүд

Аудитыг сунжруулах, холбогдох журам зааврыг зөрчих, хэрэглэгчдэд санхүүгийн мэдээлэл буруу ташаа ойлгогдох, удирдлага болон санхүүгийн ажилтнууд хариуцлага хүлээх эрсдэл үүснэ.

Зөвлөмж

1. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг мөрдөж, төсвийн шууд захирагч нарын тайланг нэгтгэхдээ хяналтыг сайжруулж, байгууллага бүрийн тайланг аудит хийгдсэн дүнтэй тулган авч байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах болно.

Асуудал 2: Зардал

Тэргүүлэх ач холбогдол №2

Илрүүлэлт

2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн тодотголоор халамжийн сангийн зардлыг 463.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд гүйцэтгэлээр уг зардал 489.6 сая төгрөгөөр хэмнэгджээ. Халамжийн сангийн 2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах явцад тодруулахад ХХҮГ нь зардал нэмэгдүүлэх санал, тооцооллыг өгөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 31 дүгээр зүйлийн 31.4.5 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Хариуцах ажилтан

Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий нягтлан бодогч

Эрсдэлүүд

Төсөв үндэслэлтэй төлөвлөгдөхгүй байх, холбогдох хууль тогтоомж зөрчигдөх, хөрөнгийн ашиглал үүсэх, удирдлага болон санхүүгийн ажилтнууд хариуцлага хүлээх эрсдэлтэй.

Зөвлөмж

1. Төсвийг төлөвлөх болон тодотгохдоо Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг баримталж, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэж байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах болно.

Илрүүлэлт

Дархан Ус суваг ОНӨХК-д орон нутгийн төсвөөс олгож буй 108.1 сая төгрөгийн усны үнийн зөрүүг “хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас” зардлын ангилалд оруулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Мөн Ахмадын хорооны ажиллагсдын 5.1 сая төгрөгийн урамшууллыг уг байгууллагын санхүүжилтээс тусад нь “нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал” зардлаар төлөвлөжээ.

Хариуцах ажилтан

Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий нягтлан бодогч

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хэрэглэгчдэд санхүүгийн мэдээлэл буруу ташаа ойлгогдох эрсдэлтэй.

Зөвлөмж

1. Төсвийг төлөвлөхдөө Сангийн сайдын баталсан “эдийн засгийн ангилал”-ыг баримтлах.

2. Ахмадын хорооны ажиллагсдын урамшууллыг тухайн байгууллагад олгож буй санхүүжилтийн дүнд оруулж төлөвлөх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Дархан Ус суваг ХК нь орон нутгийн өмчит компани мөн боловч ЗГ-ын 2012 оны 209 дүгээр тогтоолоор гэр хорооллын иргэдийн усны үнийн зөрүүгээр тооцон Сангийн яамнаас хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас гэсэн ангиллаар хянаж, УИХ-аар батлагдаж байгаа учир хасах саналтай байна.

Илрүүлэлт

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын удирдах ажилтнуудын 2017 оны эхний хагас жилийн ажлыг дүгнэсэн боловч сүүлийн хагас жилд ур чадварын нэмэгдлийг олгох шийдвэр гараагүй байна. Гэвч 1, 6, 7, 9, 11, 13, 14, 15, 16, 17, 21, 22 дугаар цэцэрлэгүүд, Жигүүр цогцолбор, 30 дугаар сургууль, Музей, Номын сан зэрэг 16 байгууллага 10.9 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр олгожээ. Энэ нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4 дэх “Ур чадварын нэмэгдлийг олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг энэ журмын 2, 8-д заасан шалгуурыг үндэслэн тухайн байгууллагын эрх баригчийн тушаалаар шийдвэрлэнэ” гэж заасныг зөрчиж байна.

Хариуцах ажилтан

Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагч, нийгмийн бодлогын хэлтэс, төсвийн шууд захирагчийн удирдах ажилтнууд болон нягтлан бодогчид

Эрсдэлүүд

Холбогдох журам зааврыг зөрчих, төсвийн хариуцлагатай байх зарчим алдагдах, удирдлага болон санхүүгийн ажилтнууд хариуцлага хүлээх эрсдэл үүснэ.

Зөвлөмж

1. Дотоод хяналтыг сайжруулж, дээрх алдааг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах болно.

Илрүүлэлт

Дархан-Уул аймгийн Музейн захирал хүчингүй болсон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг үндэслэл болгон, хоёр ч тушаал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалтыг зөрчиж байна.

Хариуцах ажилтан

Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч

Эрсдэлүүд

Төсвийн хариуцлагатай байх зарчим алдагдах, удирдлага болон санхүүгийн ажилтнууд хариуцлага хүлээх эрсдэл үүснэ.

Зөвлөмж

1. Төсвийн шууд захирагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, чадавхижуулахад анхаарч, дотоод хяналтыг сайжруулах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЧҮЛТЭМБАТ

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ш.МӨНХБАЯР

Огноо:

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

Огноо: